

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№22/561

ШУС, НУС

2021

ИНТЕРНЭТ СЭТГҮҮЛИЙН МЭДЭЭ ТҮГЭЭХЭД ТУЛГАРЧ БУЙ
БЭРХШЭЭЛҮҮД, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Өнөболор (ChangLiang)*, Улаантуяа (WuLanTuYa)**

*ӨМӨЗО-ны Хөлөнбуйр Дээд Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**ӨМӨЗО-ны Хөлөнбуйр Дээд Сургуулийн Сэтгүүл зүйн тэнхимийн багш, МУИС-ийн Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

Түлхүүр үгс: ёс зүй, зар сурталчилгаа, макро түвшин, “дөрөв дэх хэрэгсэл”, интернэт технологи, сонин мэдээ, зуучлал

Интернэт технологи хурдацтай хөгжиж буйгаас нийгмийн сүлжээний мэдээ (сүлжээний мэдээ) түгээх нь өнөөгийн салбарын халуун сэдэв болоод байна. Дэлхийн олон эрдэмтний хүчин чармайлтаар олон улсын болон дотоодын харилцааны хүрээлэлд сүлжээний мэдээллийн харилцааны судалгааны чиглэлээр олон тооны бүтээл, баримт бичиг болон бусад судалгааны үр дүн хуримтлагдсан. Ихэнх эрдэмтэд мэдээллийн харилцааны байдал, харилцааны шинж чанар, харилцааны хэлбэр, олон нийтийн санаа бодлыг бүрдүүлэх механизм, ёс суртахууны аноми, ёс зүйн аноми гэх мэт асуудлаар сүлжээний мэдээний харилцааны асуудлыг судалдаг. Зарим эрдэмтэд энэ салбарыг тусгайлан хуваадаггүй, харин макро-түвшний судалгаа хийдэг. Энэхүү өгүүлэлд голчлон

сүлжээний мэдээ түгээлтийн агуулга, сурталчилгаа, найруулга, менежмент болон бусад асуудлын талаар судалгаа хийж, сэтгүүл зүйн эрүүл хөгжлийг үр дүнтэй хангахад онолын болон практикийн нэн чухал ач холбогдолтой засаглалын арга хэмжээний талаар тусгасан болно.

XXI зуунаас эхлэн нийгэм, эдийн засаг, соёл, шинжлэх ухаан, технологи хурдацтай хөгжиж, интернэт технологи мөн урьд өмнө байгаагүй ахиц дэвшилд хүрчээ. Энэ цаг үед мэдээллийн хурдацтай хөгжлийг дагаад мэдээ түгээх арга хэлбэр нь байнга өөрчлөгдөж, хөгжсөөр байна. Хүмүүс өдөр тутмын мэдээ мэдээллийг зөвхөн уламжлалт хэвлэл мэдээллийн хэрэгслийг ашиглахаа больж, интернэт сүлжээг ашиглан олж авах нь нэмэгдсэн. Интернэт сэтгүүлийн сонин мэдээ гэдэг нь ойролцоох шинэ мэдээний баримтуудыг мэдээлэхийн тулд сүлжээний платформ, сүлжээний технологийн тусламжтайгаар текст, зураг, дуу чимээ, хөдөлгөөнт дүрс болон бусад хэрэгслийг цогцоор нь

ашиглахыг хэлнэ (Жан Хао, 2011). Интернэт сэтгүүлийн сонин мэдээний зуучлуул нь цаг тухайд нь мэдээлэх, үргэлжилсэн ролинг тайлан хийх, бүх талын мэдээлэл хийх, олон зүйлийн хэлбэрийн мэдээлэл (Пэн Лан, 2017) зэрэг өвөрмөц онцлогоороо хүлээн авагчдын мэдээлэл олж авах хэрэгцээ шаардлагыг бүрэн хангаж өгдөг. Гэхдээ интернэт сэтгүүлийн мэдээ нь хурдацтай хөгжихийн зэрэгцээ шинэ асуудал, шинэ саад бэрхшээлтэй тулгарсаар байна.

Нэг. Интернэт сэтгүүлд мэдээ түгээхэд тулгарч буй бэрхшээлүүд.

Интернэт сэтгүүлийн мэдээнд өвөрмөц байдал, үнэн бодит байдал дутагдалтай байдаг. Өнөөдөр маш олон интернэт сэтгүүлийн мэдээ нийтлэх тавцан байж, төв, муж (өөртөө засах орон) болон орон нутгийн хэвлэл мэдээллийн нэгж зэрэг албаны интернэт сэтгүүлийн сонин мэдээний тавцангаас гадна, маш олон албаны бус цогц ба хувь хүний эрхэлсэн интернэт сэтгүүлийн мэдээ нийтлэх платформууд байна. Эдгээр интернэт сэтгүүлийн платформ дээрх мэдээ нь өвөрмөц байдлаар дутагдалтай байгаа бөгөөд үнэн бодит чанараар дутмаг байдал оршиж байна. Өвөрмөц байдлаар дутагдалтай гэдэг нь маш олон интернэт сэтгүүлийн сонин мэдээний платформ нь илүү их хүлээн авагчдын анхаарлыг татах, нэн илүү эдийн засгийн үр ашиг олох, мэдээний зардлыг бууруулах зорилгоор бусад платформуос нийтлэлийг шууд хуулбарлан нийтэлж,

орчуулан ашиглаж байна. Үнэн бодит чанараар дутмаг гэдэг нь зарим интернэт сэтгүүлийн платформ нь уншигчдын анхаарлыг татахын тулд уламжлан түгээх явцдаа мэдээний үнэн зөвийг баталгаажуулалгүйгээр нийтэлдэг байна. Ялангуяа нийгмийн мэдээ, зугаацуулах мэдээ нь уншигчдын анхаарлыг татахын төлөө сонин мэдээний гарчигт гүн утга, өнгө будаг өгч, сонин мэдээний сэдвээсээ салангид үзэгдэл болж өгдөг. Энэхүү зохион бичлэгийн арга нь интернэт сэтгүүлийн мэдээний чанар чансаанд нөлөөлж, хүлээн авагчдад сөргөөр нөлөөлдөг. Зарим интернэт сэтгүүлийн сонин мэдээ нь хүлээн авагчдын анхаарлыг нэмэгдүүлэхийн тулд, мэдээний агуулга, хэлбэрээс үл хамааран, үйл явдлын зөвхөн нэг талыг барьсан байдлаар танилцуулах, эсвэл гүнзгий дүн шинжилгээ хийхгүйгээр мэдээг нийтэлж, улмаар интернэт сэтгүүлийн хамгийн чухал шинж чанар болох үнэн бодит чанараа алдахад хүргэдэг байна.

Интернэт сэтгүүлийн сонин мэдээний зар сурталчилгаа маш ноцтой болж байна. Онлайн мэдээний сувгууд нь ихэвчлэн мэдээллийн медиа нэгжүүд, портал вэбсайтууд, салбарын вэбсайтууд, олон нийттэй харилцах компаниуд, медиа корпорацууд, WeChat олон нийтийн хэрэгсэл, богино видео платформууд гэх мэт. Эдгээр түгээлтийн сувгуудын дунд мэдээллийн медиа нэгжээс бусад интернэт сэтгүүлийн зар сурталчилгаа олон интернэт сэтгүүлийн платформууд нь үзэгчдийн анхаарлыг татаж хандалт

авсны дараа зар сурталчилгааг интернэт сэтгүүлийн мэдээнд янз бүрийн хэлбэрээр оруулдаг. Мэдээж интернэт сэтгүүлийн платформын хувьд зар сурталчилгааны орлого нь эдийн засгийн үр ашгийн хамгийн чухал зүйл юм. Гэхдээ зарим интернэт сэтгүүлийн вэбсайт эсвэл платформ дээрх зар сурталчилгаа нь том орон зайг эзэлж, хэвлэлийн мэдээний байршлыг давсан байна. Тэр ч байтугай интернэт сэтгүүлийн нэг мэдээнд нэгээс илүү төрлийн онлайн зар сурталчилгаа байх нь элбэг. Олон төрлийн зар сурталчилгаа, баннер сурталчилгаа, холбоос зар, и-мэйлийн сурталчилгаа, урсдаг зар, тусгай зар гэх мэт.

Интернэт сэтгүүлийн мэдээ хэт их зар сурталчилгаа нь мэдээний чанар, уншигчдын унших мэдрэмж, гоо зүйд сөргөөр нөлөөлж байна. Олон тооны онлайн платформ дээр үзэгчдийн анхаарлыг тодорхой хэмжээгээр татаж авсны дараа зар сурталчилгааг мэдээнд янз бүрийн хэлбэрээр оруулж болдог.

Интернэт сэтгүүлийн мэдээнд мэргэжлийн редакцын баг дутагдаж байна. Одоогийн байдлаар интернэт сэтгүүлийн мэдээний хэвлэн нийтлэх платформ олон байгаа бөгөөд нийтлэгдсэн онлайн мэдээний чанар жигд бус байна. Мэдээллийн медиа нэгжүүдийн мэргэжлийн сүлжээний мэдээний редакторын авьяас чадварыг эс тооцвол бусад платформ дээр интернэт сэтгүүлийн мэргэжилтнүүдийн хомсдол их байна. Интернэт сэтгүүлийн мэдээний авьяас чадвартай хүмүү-

сийг үндсэндээ хоёр ангилалд хуваадаг бөгөөд нэг нь онлайн мэдээ цуглуулах, засах авьяас чадвартай хүмүүс, нөгөө нь онлайн мэдээ нийтлэх ур чадвартай авьяастай боловсон хүчин юм.

С*истемтэй, мэргэжлийн түвшинд суралцсан онлайн мэдээ нийтлэх ур чадвартай, авьяаслаг хүн дутмаг эсвэл хоёр төрлийн авьяас чадварын тогтолцоо төгс бус байгаа нь олон платформ интернэт сэтгүүл зүйг гүйцэтгэх чадваргүй болоход хүргэсэн.* Одоо зарим сүлжээний платформын онлайн мэдээний редакторууд уламжлалт мэдээллийн хэрэгслийн мэдээллийг шууд хуулж буулгаж, өөрсдийн онлайн платформ дээр байрлуулж нийтлэх үзэгдэл их байна. Мэдээний хувилбарын байршлын зураг төсөл нь мөн тогтсон загвар, тогтсон хэв маяг бөгөөд агуулга, хэлбэрийн хувьд шинэчлэл байхгүй. Гэвч өнөө үед илүү их эрэлттэй, алдартай байгаа богино хэмжээний видео платформууд (Tik Tok, Kuaishou, Tencent Weishi гэх мэт) дээр мэдээллийн олон суваг байдаг. Орон нутагт олон хэвлэл мэдээллийн хэрэгсэл бүртгүүлсэн байдаг. Гэхдээ эдгээр мэдээллийн сувагт нийтлэгдсэн онлайн мэдээнд олон тооны дахин хэвлэгдэх, хулгайлсан мэдээлэл элбэг байна. Үүний зорилго нь хандалт их авах хүсэл эрмэлзэл юм. Нэмж дурдахад, олон интернэт сэтгүүлийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд өөрийн сэтгүүлч, редактор байдаггүй, зарим дадлагажигч нар зохих мэргэжлийн чадваргүй байдаг

тул мэдээ эмхэтгэхэд үг үсгийн, найруулгын алдаа байнга гардаг. Сэтгүүл зүйн мэргэжилтэн дутмаг байгаа нь мэдээлэл түгээх чиглэлээр онлайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн эрүүл хөгжлийг хязгаарлаж байна.

Хяналт, удирдлага хангалтгүй байна. Мэдээний веб сайтуудын тоо тасралтгүй нэмэгдэж, онлайн мэдээний платформууд нэмэгдэхийн хэрээр онлайн мэдээ гаргах явцад хяналт, удирдлага хангалтгүй байна. Интернэт сэтгүүлийн мэдээг нийтлэхдээ уламжлалт сонинд тавигддаг шаардлагыг бүрэн тавьж нийтлэх боломжтой гэж заасан байдаг. Гэхдээ олон онлайн мэдээллийн платформууд зах зээлийг тэргүүлж, үзэгчдийг татах зорилгоор дуусаагүй онлайн мэдээг шууд нийтэлдэг үзэгдэл байдаг. Уншигчдын анхаарлыг татахын тулд зарим онлайн платформууд үйл явдлыг хэд хэдэн хэсэгт хувааж, хэсэгчлэн мэдээлж, уншигчид эргэлзээ төрүүлж, хүлээн авагчид горьдлого бий болгож байдаг нь энгийн үзэгдэл болсон. Тэр ч байтугай зарим онлайн мэдээ зөвхөн эхлэл, үйл явцтай байдаг бөгөөд эцсийн үр дүн гардаггүй. Зарим мэдээ нь "үргэлжлэл бий, мөн дараа нь мэдээлэх болно" гэсэн үгсээр төгсгөж, эцсийн үр дүнг цаг тухайд нь мэдээлдэггүй учир цаг тухайд нь мэдээлэх шинж чанараа алдаж байна. Зарим хэвлэлийн мэдээний шаардлагагүй платформууд өөр мэдээний платформыг ашиглаж онлайн мэдээ нийтэлж байна. Онлайн мэдээний хяналт, менежментийн систем нь төгс бус

тул мэдээний үнэн бодит байдалд зарим далд аюулыг авчирдаг.

Хоёр. Интернэт сэтгүүлийн мэдээ түгээхэд тулгарч буй асуудлыг шийдвэрлэх арга зам.

Интернэт сэтгүүлийн мэдээний найдвартай байдлыг нэмэгдүүлэх. Интернэт сэтгүүлийн мэдээний платформ нь мэдээний үнэн бодит, өвөрмөц байдлыг баталгаажуулах ёстой. Үүний тулд сэтгүүлчдийн хариуцлагыг нэмэгдүүлж, онлайн мэдээ нийтлэх дүрэм журмыг баримталж, нийтэлсэн онлайн мэдээг баримтаар баталгаажуулсны дараа интернэтэд нийтлүүлэх, мэдээний үнэн бодит, өвөрмөц байдлыг хянах, ижил мэдээний хооронд хуулж буулгахаас зайлсхийх шаардлагатай. Эх сурвалжаас эхлэн агуулгыг хянаж, худал мэдээлэл, нийгэмд хэт дуулиан шуугиан тарааж буй мэдээллийг ахин нягтлах хэрэгтэй. Интернэт сэтгүүлийн редактор нийтлэгдсэн онлайн мэдээний үнэн баримттай байдлыг баталгаажуулж, уншигчийн итгэл үнэмшлийг дээшлүүлэх үүрэгтэй. Зөвхөн мэдээний үнэн бодит байдал, өвөрмөц чанарыг дээшлүүлж, онлайн мэдээний орон зайг цэвэршүүлснээр платформуудын мэдээний хөгжлийн маш сайн үндэс суурийг тавьж өгнө.

Интернэт сэтгүүлийн мэдээ, зар сурталчилгаа хоёрын харьцааг оновчтой зохицуулах хэрэгтэй. Зар сурталчилгаа нь онлайн мэдээг гаргах явцад орлогын чухал зүйлсийн нэг юм. Онлайн мэдээний олон платформ нь зар сурталчилгааны орлогоор дамжуулан орлогоо нэмэг-

дүүлдэг. Мэдээ, зар сурталчилгааг нийтлэхдээ байршил дизайныг оновчтой зохион байгуулж, гол мэдээг зар сурталчилгааг дагалдах хэрэгсэл болгон байрлуулна. Зар сурталчилгааг бүх хуудсанд гол хэсэг болгон ашиглах боломжгүй. Энэ нь онлайн мэдээ байх анхны санаагаа алддаг. Зар сурталчилгааг санамсаргүй байдлаар нийтлэхээс мэдээтэй холбоотой зарим зар сурталчилгааг интернэтийн мэдээний агуулгад үндэслэн нийтэлж болдог. Жишээлбэл, спортын арга хэмжээний талаарх онлайн мэдээг нийтлэхдээ спортын барааны сурталчилгаа, баярын тухай онлайн мэдээ нийтлэхдээ аялал жуулчлалын газруудын сурталчилгааг нийтэлж болно. Онлайн мэдээнд зар сурталчилгааны агуулга, зар сурталчилгааны зохион байгуулалтыг оновчтой зохицуулж, үзэгчдийн хүлээн авах мэдээ мэдээллийн хэмжээг нэмэгдүүлэх, ингэснээр онлайн мэдээ мэдээллийг түгээх нь үр дүнтэй, эрүүл хөгжих боломжтой болно. Зөвхөн өөрийн оригинал, өвөрмөц сайжруулах, онлайн мэдээг орон зай цэвэршүүлэх замаар мэдээ хөгжлийн маш сайн үндэс суурийг тогтоож болно.

Интернэт сэтгүүлийн тусгай мэргэжлийн мэдлэг, ур чадвартай ажилтнуудыг элсүүлэн ажиллуулах. Интернэт сэтгүүлийн мэдээний чанар чансааг түүний сэтгүүлчдийн ур чадвар тодорхойлдог. Мэдээллийн медиа нэгжүүдийн сүлжээний мэдээний ажилтнуудаас бусад платформ дээрх сүлжээний мэдээний редак-

торуудын ихэнх нь сэтгүүл зүйн мэргэжлийн бус хүмүүс байдаг. Мэргэжлийн бус хүмүүс мэдээнд мэдрэмтгий байдал, мэдээ засварлах үйл явц, мэдээ засах журам, мэдээний шалган хяналтад учир дутагдалтай ханддаг. Сэтгүүл зүйн мэргэжилтнүүд мэргэжлийн мэдлэгийг системтэйгээр сурч, мэргэжлийн байр сууриа хурдан эзэмшиж, мэргэжлийн албан тушаалд хурдан орох боломжтой байдаг. Тиймээс онлайн мэдээний платформууд асуудлыг мэргэжлийн түвшинд шийдэж цаашид амжилттай ажиллахын тулд мэргэжлийн сэтгүүлчдээ бэлдэн ажиллуулахад чадах бүхнээ хийх хэрэгтэй. Онлайн мэдээний платформуудын хувьд онлайн мэдээг системтэй судалж үзсэн мэргэжилтнүүдийг ажиллуулж, асуудлыг мэргэжлийн үүднээс судлуулах нь зүйтэй юм. Сэтгүүл зүй бол тасралтгүй шинэчлэгдэж, өөрчлөгдөж, хөгжиж байдаг салбар. Залуу хүмүүсийн сэтгэх чадвар, инновацын чадвар харьцангуй өндөр байдаг. Тиймээс онлайн дахь сэтгүүлчдийн онцлог шинж чанараас харахад, платформ нь ажлын байрны өрсөлдөөнөөр тохируулах арга хэлбэрийг бий болгож, шагнал, шийтгэлийн системийг ашиглах аргаар залуу сэтгүүлчдийг урамшуулах, онлайн мэдээг цуглуулах, засах, хянах, нийтлэх ажлын явцыг сайжруулж оновчтой болгох нь зүйтэй юм.

Интернэт сэтгүүлийн мэдээний хяналт, менежментийг бэхжүүлэх. Интернэт сэтгүүлийн сүлжээний хяналт, хамааралт, удирдлагын тогтолцоог бэхжүүлж, сүлжээний жин-

хэнэ нэрийн системийг цогцоор нь сурталчлан хянаж, хэрэгжүүлэх ёстой. Сүлжээний мэдээний платформ, интернэт хэрэглэгчдийн тоо тасралтгүй нэмэгдэхийн хэрээр сүлжээний хяналт, менежментэд сорилт тулгараад байгаа бөгөөд платформын хувьд дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй: нэг нь платформ дээр мэдээ нийтлэхээсээ өмнө сүлжээний мэдээ нийтлэх эрх авах, нөгөө нь хэвлэн нийтлэхийн зэрэгцээ хяналт, удирдлагын тогтолцоог бэхжүүлэх, хаалгачдын тогтолцоог бэхжүүлэх, платформ дээр нийтлэхээс өмнө хэвлэгдэх интернэт сэтгүүлийн мэдээг хянах шаардлагатай байна.

Мэдээний вебсайтуудын жинхэнэ нэрийн системийг бүрэн хэрэгжүүлэх шаардлага нь кибер орон зайг цэвэршүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. 2015 оны хоёрдугаар сарын 4-ний өдөр БНХАУ-ын Кибер сансрын захиргаанаас гаргасан “Интернэт хэрэглэгчийн дансны нэрийг удирдах журам” -д “Интернэт мэдээллийн үйлчилгээ үзүүлэгчид арын хэсгийн жинхэнэ нэр, урд талын сайн дурын” гэсэн зарчмыг баримталж, интернэт мэдээллийн үйлчилгээ хэрэглэгчдийг бодит үнэмлэхийн баталгаажуулалтыг хийсний дараа дансанд бүртгүүлэхийг шаардах ёстой” (Интернэт хэрэглэгчийн дансны нэрийг удирдах журам, 2015) гэж заасан байна. Онлайн мэдээний платформууд нь бүх мэдээ гаргах явцад өөрсдийнхөө ажлыг сайн хийх ёстой. Хамтран ажиллаж байж онлайн мэдээллийн түгээлт нь илүү сайн, эрүүл хөгжих боломжтой юм.

Дүгнэлт. Сүлжээний технологи болон мэдээлэл түгээх технологи хурдацтай хөгжиж, сүлжээний медиа хурдацтай нэмэгдэж байгаа нь өнөөгийн нийгэмд маш их нөлөө үзүүлж байна. Интернэт сэтгүүлийн мэдээ нь мэдээ түгээх ажлыг хурдасгаж байгаа боловч хүсээгүй зарим сөрөг нөлөөг авчирсан. Тиймээс хөгжлийн чиг хандлагын дагуу хяналт, менежментийг сайжруулах, тусгай мэргэжлийн мэдлэг ур чадвартай ажилтнуудыг нэмэгдүүлэх, онлайн мэдээний хуудсыг оновчтой ашиглах, онлайн мэдээний итгэл үнэмшил, найдвартай байдлыг сайжруулан дээшлүүлэх шаардлагатай байна. Зөвхөн ийм байдлаар эв нэгдэлтэй сүлжээний орчныг бий болгож, бүрдүүлж чадна. Онлайн мэдээ нь олон нийтийн санаа бодлыг зөв чиглүүлж, эерэг хандлагыг олон нийтэд түгээх, интернэтийн мэдээ, хэрэглээ хар бараанаасаа илүүтэйгээр эрүүл хөгжих боломжийг дэмжих ёстой.

Эшлэл

1. Жан Хао. 2011. Шинээр эмхэтгэгдсэн мэдээ бичих ур чадварын жишээний тайлбар. Бээжин. Ху. 180.
2. Пэн Лан. 2017. Сүлжээний харилцааны танилцуулга. Бээжин. Ху. 143.
3. Интернэт хэрэглэгчийн дансны нэрийг удирдах журам, 2.4 дэх хэсэг. 2015. Үндэсний интернэт мэдээллийн албаны редакцын хэлтэс. Бээжин.

Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Лэй Юүжиэ, Шин Шин. 2010. Сүлжээний харилцааны танилцуулга . Бээжин.
2. Лю Шиаошяо. 2018. Шинэ хэвлэл мэдээллийн эрин үед манай улс дахь цахим мэдээний эерэг энерги түгээлтийн талаарх судалгаа. Чунцин.
3. Ян Сяолин. 2019. Сүлжээний мэдээллийн харилцааны аномийн шинжилгээ ба түүний эсрэг арга хэмжээ. Харбин.
4. Хэ Пин. 2017. Манай улсын Сүлжээний мэдээ түгээх аноми ба засаглалын талаарх хэлэлцүүлэг. Бээжин.
5. Лян Сяо. 2017. Марксист мэдээний үүднээс Сүлжээний мэдээ түгээх аноми ба засаглалын талаарх судалгаа.
6. Гуйжоу. Жан Хао. 2011. Шинээр эмхэтгэгдсэн мэдээ бичих ур чадварын жишээний тайлбар. Бээжин.
7. Пэн Лан. 2017. Сүлжээний харилцааны танилцуулга. Бээжин.
8. Үндэсний интернэт мэдээллийн албаны редакцын хэлтэс. Интернэт хэрэглэгчийн дансны нэрийг удирдах журам. Бээжин.

Summary

With the popularization and rapid development of the Internet, the way of disseminating news has also undergone tremendous changes. People have become accustomed to using computers and mobile phones to browse news every day. Online news has become an important channel for many people to understand current affairs. Although online news is more convenient and timely to report news information than traditional news, there are also some problems in reality, which have a bad impact on the entire online news. This article mainly studies some problems existing in the process of network news dissemination, and proposes corresponding solutions according to the actual situation.